

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 1161

Улаанбаатар хот

Зарим үйлчилгээний үнэ, тарифыг
шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/35 тоот тушаалаар баталсан “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3, төвийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.15, дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 06/1266 тоот албан бичгийн дагуу “Үндэсний дата төв” УТҮГ-ын Захирлын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/36 тоот тушаалын хавсралтаар баталсан “Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ” болон “Зогсуур түрээсийн үйлчилгээний” үнэ, тарифыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Тус төвөөс үйлчилгээ авч буй хуулийн этгээдүүдэд мэдэгдэл хүргэн, гэрээ шинэчлэн байгуулан ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн Хэрэглэгчийн үйлчилгээний мэргэжилтэн (Д.Энхтөгс)-д үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан холбогдох үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс (Ж.Нямгэрэл)-т даалгасугай.

Дөрөв. “Үндэсний дата төв” УТҮГ-ын Захирлын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/36 тоот тушаалын хавсралтаар баталсан “Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ” болон “Зогсуур түрээсийн үйлчилгээний” үнэ, тарифыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ

М.БАТТУЛГА



“Үндэсний Дата Төв” УТҮГ-ын захирлын
2023 оны 06 сарын 19 өдрийн
тоот тушаалын хавсралт

A.1.1



**Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үзүүлэх
үйлчилгээний үнэ,тариф**

1. Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ	Портын тоо(ETH/SPF/SPF+)	Сар	100,000₮
Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ	Портын тоо(QSFP+/QSFP28)	Сар	300,000₮
Холболтын хураамж/нэг удаагийн/			200,000₮

2. Зогсуур түрээсийн үйлчилгээ

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Зогсуур түрээсийн үйлчилгээ	1 UNIT	Сар	50,000₮
Зогсуур түрээсийн үйлчилгээ	1 RACK (42 UNIT)	Сар	1,100,000₮
Нэмэлт үйлчилгээ IP хаяг	1ширхэг	Сар	5,000₮